

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан
/СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ/

Д/Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
“НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:			
1.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөл, эндэгдлийг бууруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулан, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.			
1.1.1	Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр ханган, барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.	Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлыг 2022 оноос эхлэн төлөвлөж 2024 оны 08 дугаар сард барилгын А корпус хэсгийг бүрэн засварлаж ашиглалтад оруулсан. 2026 оны эхний хагас жилд тус барилгын Б корпусыг засварлаж дуусаад байна. 	100%
1.1.2	Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулан, эрүүл мэндийн нийгмийн ажилтануудыг чадавхжуулж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ	Эрүүл мэндийн төвийн Б блокийг Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн. Тус барилгын Б блокын хэсэгт их засварын ажил хийгдэж дууссан нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлж эхлээд байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтанд хамруулсан байна. Үүнд: 1. Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран “Өсвөр насны жирэмслэлт ба тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэлт” сэдэвт 1кр сургалтанд 14 эрүүл мэндийн нийгмийн ажилтанг чадавхжуулсан.	85%

		2. Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран “Сэтгэцийн эрүүл мэндийн ерөнхий ойлголт”сэдвээр 20 эрүүл мэндийн нийгмийн ажилтанг чадавхжуулсан. 3. Папиллома вурсын урьдчилан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалт сэдвээр 17 эрүүл мэндийн нийгмийн ажилтанг чадавхжуулсан.	
1.1.3	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, өвчлөл эндэгдлийг бууруулан	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдсан хүн ам: 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 сарын 01-нийг хүртэл эрт илрүүлэг үзлэгт СХД –н хэмжээнд 43 хорооны 341,390 хүн хамрагдахаас 40% буюу 133,268 иргэн хамрагдсан байна. Эрт илрүүлэг үзлэгийг 2025 оны 10 сараас эхлэн түр зогсоосон байна. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг ЭМСайдын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/145 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.6, 2.1.7, 2.1.8, 2.1.9, 2.1.10, 2.1.11, 2.1.12-д заасан ажил үйлчилгээ, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 2022 оны 49/А/118 тушаал СХДЭМТөвийн даргын 2025оны 12сарын 22ны өдхийн А/111төлбөртэй тусламж үйлчиллгээний журмын хүрээнд байгууллагуудтай, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ГЭРЭЭ” байгуулан ажиллаж байна. 2025 оны 2-р улирлын байдлаар 82 байгууллагтай гэрээтэй ажиллаж 7159 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн байна. Үүнээс: 72 байгууллагын 6216 хүнд эрүүл зүйн шинжилгээ/цагаан дэврийн шинжилгээ хийгдсэн. 10 байгууллагын захиалгаар-943 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн.	70%
1.1.4	Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөл, боломж, нийгмийн баталгааг хангахад.	- Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөл, боломж, нийгмийн баталгааг хангах чиглэлээр: 2026 онд өндөр насны тэтгэвэрт суухаар хүсэлтээ ирүүлсэн 16 ажилтны тэтгэмж төсөвт суулгасан. Үүнээс тэтгэвэр тогтоолгон ирсэн 1 ажилтанд тооцооллыг хийж тушаалыг гарган, 40.757.442,00 төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг олгуулахаар НЭМГ-т холбогдох материалыг хүргүүлээд байна. - СХД Эрүүл мэндийн төвийн нийт ажилчин, албан хаагчдын нийгмийн хамгаалалтыг хангах чиглэлээр 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 4,454,022,983.11 төгрөг олгосон. Үүнд: ➤ Бодогдсон цалин 2,880,904,883.42	60%

		➤ Илүү цаг нэмэгдэл хөлс 267,263,838.41 ➤ Шөнө цаг нэмэгдэл хөлс 86,878,156.64 ➤ Нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс 7,563,666.52 ➤ Хавсран, хослон, түр орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлс 73,152,224.24 ➤ Ур чадварын нэмэгдэл 70,259,975.78 ➤ Алба хаасан хугацааны нэмэгдэл 219,312,342.78 ➤ Мэргэшлийн зэргийн нэмэгдэл 55,775,714.82 ➤ Онцгой нөхцөлийн нэмэгдэл 53,510,982.06 ➤ Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл 89,827,723.44 ➤ Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал 24,652,475.00 ➤ Хоолны хөнгөлөлтийн дүн 531,573,000.00 ➤ Нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн дүн 93,348,000.00 Олон улсын эмч, сувилагч нарын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “ЭРДМИЙН ЧУУЛГАН – 2026” эрдэм шинжилгээ, судалгааны бага хурал 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тус хуралд СХДЭМТ болон ӨЭМТ-ийн эмч нарын 27 бүтээл, сувилагч нарын 14 судалгааны ажлыг хүлээн авч, шалгаруулалтын үндсэн дээр 18 илтгэлийг хоёрдугаар шатанд хэлэлцүүлсэн. ➤ Тэргүүн байр: “Интубацийн гуурстай ерөнхий мэдээгүйжүүлэгтэй хэвлийн дурангийн мэс засалд орсон өвчтнүүдэд Aptel оноогоор үнэлж, PONV-ээс сэргийлэх практик ач холбогдол” Мэдээгүйжүүлгийн эмч Т.Мөнхбаатар ➤ Дэд байр: “Ходоод, дээд гэдэсний шархлаа өвчнийг үүсгэж буй зонхилох эрсдэлт хүчин зүйлсийг судалсан байдал” Дурангийн эмч Б.Болортуяа ➤ Гутгаар байр: “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагч нарын сэтгэлзүйн байдлыг үнэлэх” ӨЭМТ-ийн эмч С.Аззаяа Сувилахуйн аман илтгэл: ➤ Тэргүүн байр: “Сувилагч мэргэжлийн үнэ цэнэ” Сувилагч Д.Отгонцэцэг ➤ Дэд байр: “Сувилагчийн ажлын байрны стресс, сэтгэл түгшилтийг нойрны чанартай холбон судалсан нь” Аргазүйч сувилагч Б.Эрдэнэчимэг	
--	--	---	--

		➤ Гутгаар байр: “ЕБС-ийн 11–17 насны сурагчдын дундах В вирусын дархлаа тогтоцыг үнэлсэн байдал” Сувилагч Э.Наранчимэг Ханын илтгэл: ➤ Тэргүүн байр: “СХДЭМТ-ийн ажилчдын дунд метициллин д тэсвэртэй Staphylococcus aureus-ын колонизацийг илрүүлэн, деколонизацийн үр дүнг судалсан нь” Оношзүйн нэгдсэн лаборатори Ш.Отгончимэг ➤ Дэд байр: “Эхээс хүүхдэд дамжих HBV халдварын тархалт ба дархлаа тогтоц” ➤ Жирэмсний дотрын эмч Г.Буянжаргал Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, чиглэж Эмнэлзүйн ур чадварын өрөө гарган тохижуулж, шаардлагатай хэрэгслээр хангаж 2026 оны хагас жилийн байдлаар дараах сургалт, уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулсан: ➤ Ажлын байран дээр сувилагч нарын гардан ажилбар ур чадвар онолын мэдлэг яаралтай тусламжийн бэлэн байдал зэргийг сайжруулахаар сургалт 10 удаа явуулж давхардсан тоогоор 287 сувилагч хамрагдсан ➤ Эмнэл зүйн ур чадварын өрөөг тохижуулан шаардлагатай хэрэгслээр ханган сургалт явуулах орчинг бүрдүүлж 3 удаагийн явуулж дадлага сургалтад 73 сувилагч хамрагдсан. ➤ Сувилахуйн албанаас өрхийн сувилагч нарт амилуулах тусламж үзүүлэх хөх код идэвхижүүлэх талаар сургалт хийх мэдлэг ур чадварыг	
--	--	--	--

		дээшлүүлэх, тохиолдол эрсдэлээс сэргийлэх, эмчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зохион байгууллаа. Тус сургалтаар: ➤ Хөх код идэвхижүүлэх ➤ Яаралтай тусламжийн тэргэнцэрт байх эм хэрэгсэл нэг удаагийн хэрэгслийн бэлэн байдал Өндөр эрсдэлт эмийн журам зэрэг сэдвүүдээр хичээл орсон. 2026 оны 03 сарын 04 ний өдөр зохион байгууллаа. Сургалтанд өрхийн эрүүл мэндийн төвүүд болон СХДЭМТ-ийн нийт 27 сувилагч хамрагдсан.	
1.1.5	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, яаралтай тусламж үзүүлэх чадавхыг нэмэгдүүлнэ.	1. 2026 оны 4-р сарын 6-наас 9-ны хооронд “Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дэмжлэгт хяналт, үнэлгээ хийх удирдамж”-ийн дагуу өрхийн менежер М.Норжмаа, Я.Ариунзул, халдвар судлаач Л.Эрдэнэцэцэг, ХТҮХЗ эмч Г.Амар, НҮТҮХЗ эмч Ц.Даваасүрэн нараар ажлын хэсэг бүрдүүлэн Эмнэлгийн тусламж үйлчилгээ болон Яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдал, Хүүхдийн тусламж үйлчилгээ, Нөхөн үржихүйн эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, Халдвараас сэргийлэх хяналтын нийт 4 чиглэлээр 27 ӨЭМТ-үүдэд хяналт хийсэн ба цаашид сайжруулах чиглэл өгсөн. 2. 2026 оны 4 сарын 27-ны өдөр ӨЭМТ-н ахлах сувилагч нарын шуурхай хурлыг Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан дарга Наранцэцэг, Чанарын албаны эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан менежер Тунгалаг нартай хамтран зохион байгуулж яаралтай тусламжийн бэлэн байдал болон эм,эмнэлэгийн хэрэгслийн жагсаалтыг нэгдсэн ижил жагсаалттай болгох талаар хэлэлцэж шийдвэрлэсэн. 3. Эрүүл мэндийн төвийн даргын А/16 тоот “Амилуулах яаралтай тусламжийн бэлэн байдал багийн үйл ажиллагааг сайжруулах “Алтан хором-5” ур чадварын тэмцээнийг төвийн Нийгмийн эрүүл мэндийн алба, Чанарын алба, Сувилахуйн тусламж үйлчилгээний алба, Хүлээн авах яаралтай тусламжийн тасгуудтай хамтран 2026 оны 3-р сарын 14-ны өдөр харъяа 26 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хооронд 2026 оны 03 сарын 14-ны өдөр зохион амжилттай байгуулж	100%

		4 бүс тус бүрээс шилдэг 4 баг Энх-Ачит, Батцэцэн, Мичид-Ундрага, Ээлтэй шалгарч дараагийн шатанд өрсөлдсөн.	
1.1.6	Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, эмчлэх үйл ажиллагааг сайжруулах “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв-ийн даргын 2026 оны А/33 дугаар тушаалыг баталж, халдварт өвчний үед ажиллах шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулсан. Халдварт өвчний нөхцөл байдалд тогтмол тандалт хийж, хам шинжийн болон сэжигтэй тохиолдлын мэдээ, мэдээллийг тухай бүр хүлээн авч, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй эргэн мэдээлэл солилцон, голомтод халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, ариутгал халдваргүйтгэл хийх, зөвлөмж мэдээллээр хангах ажлыг шуурхай зохион байгуулан ажилласан. 2026 оны эхний хагас жилийн байдлаар халдварт өвчний хам шинжийн болон сэжигтэй тохиолдол 10,000 хүн амд 31.7 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн халдварт өвчний нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг дээд шатны байгууллагад тухай бүр хүргүүлж, эргэн мэдээллийг тогтмол авч ажилласан. Цаашид халдварт өвчний эрт илрүүлэг, тандалт судалгааг эрчимжүүлэх, голомтод авах хариу арга хэмжээний шуурхай байдлыг нэмэгдүүлэх, байгууллага, иргэдийн урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллана. Томуу, томуу төст өвчний /ТТТӨ/ дэгдэлтийн нөхцөл байдлыг тогтмол хянах зорилгоор дүүргийн хэмжээнд өдөр бүр хийгдэж буй амбулаторийн үзлэгийн мэдээнд ТТТӨ-ний эзлэх хувийг тооцон мэдээлж, тандалтын үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэн ажилласан. ТТТӨ-ний үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар сургууль, цэцэрлэгийн эмч нарт зориулсан чадавхжуулах сургалтыг 1 удаа зохион байгуулж, нийт 49 эмч, мэргэжилтнийг хамруулсан. 2026 оны эхний хагас жилийн байдлаар улаанбурхан өвчний 128 тохиолдол бүртгэгдэж, тандалт судалгаагаар нийт 1652 ойрын хавьтлыг тогтоон голомтод хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулсан. Ойрын хавьтлын 594 буюу 72 хувийг голомтын дархлаажуулалтад хамруулж, зөвлөмж мэдээлэл өгч ажилласан.	70%

		Мөн улаанбурхан өвчний үед авах хариу арга хэмжээ, оношилгоо, эмчилгээний чиглэлээр Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн халдварт өвчин хариуцсан эмч нарт 2 удаагийг н сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 47 эмч, мэргэжилтнийг хамруулсан. Зонхилон тохиолдох гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн сайдын А/527 дугаар тушаал “Халдварт өвчний тохиолдлыг тандах”, А/528 дугаар тушаал “Зонхилон тохиолдох гэдэсний бактерт халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх заавар” болон бусад холбогдох тушаал, зааврыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Жаргалант тосгоны Ерөнхий боловсролын 74, 121 дүгээр сургуулийн дотуур байр болон асрамж, халамжийн 3 төвүүдэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 төрлийн 12 нэр төрлийн брошур, зөвлөмж боловсруулан 140 гаруй иргэдэд түгээн, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулсан. ХПВ вакцины 2026 оны дархлаажуулалтын 3 сарын 6-ны өдрөөс эхлэн сургуульд суурилан явагдаж байна. 5-р сарын 25-ны байдлаар хүний папиллома вирусын эсрэг вакцинаар 11 настай 8282 хүүхдээс 6004 хүүхдийг дархлаажуулж 74.7%, 12 настай хамрагдвал зохих 8236 хүүхдээс 5031 хүүхдийг дархлаажуулалтанд хамруулж 61.1%-ийн хамралттай байна.	
1.1.7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг түгээх, шинээр ашиглалтад орж буй барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хотын стандартад нийцүүлнэ.	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А/90 тоот захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй зорилтот бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж байна. 2026 оны 2-р сарын 5-наас 13-ны өдрүүдэд Өрхийн эрүүл мэндийн төвүүд нийт 418 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзлэг, оношлогоог хооронд хийж ажилласан. Үзлэгээр: 1. Цусны ерөнхий шинжилгээ 2. Шээсний ерөнхий шинжилгээ 3. Захын цусанд глюкоз хэмжих 4. Элэгний В,С вирусын маркер тодорхойлох 5. Хэвлийн ЭХО	70%

6. Зүрхний цахилгаан бичлэг

7. Биоэнергийн аппарат ашиглан оношилгоо, шинжилгээ хийж шаардлагатай иргэдэд гэрийн эмчилгээ, дархлаа дэмжих бүтээгдэхүүнүүдийг тараалаа.

Мөн хэвтрийн ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран хамгаалагч нарт асаргаа зөвлөгөө болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



1. ДОХИОНЫ ХЭЛНИЙ СУРГАЛТ

	Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 17-ны өдрийн А/512 тоот тушаалыг хэрэгжүүлэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлэх мөн Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэн сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй тусламж үйлчилгээ үзүүлэх, эмч, ажилчдыг чадавхжуулах зорилгоор “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Ахмад мэргэжилтэн Б.Дуламжав багштай хамтран “ДАКТИЛЬ ЦАГААН ТОЛГОЙ, ДОХИОНЫ ХЭЛ”-ний сургалтыг 2026 оны 4 сарын 6-наас эхлэн сургалтын үйл явц үргэлжилж байна. Сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчид хүрч үйлчлэх, хүртээмжтэй байх үүднээс лавлагаа мэдээллийн менежер, эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, хувцас олгогч, арга зүйч, даатгалын тасгийн эмч, мэдрэлийн өвчин судлалын сувилагч нарыг сургалтанд хамруулсан бөгөөд нийт 15 эмнэлгийн ажилтан сургалтанд хамрагдаж байна.	
	  СХДЭМТ нь 2026 оны эхний хагас жилд барилгын их завсар хийгдэж дууссан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан стандартын лифт буюу цахилгаан шатыг ашиглалтанд оруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэгш хүртээмжтэй үйлчлүүлэх орчныг бүрдүүлээд байна.	
Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.	1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 07 ний өдөр зохион байгуулагдсан “Цасны баяр 2026” арга хэмжээнд нийт 16 ажилтан албан хаагчид гар барилдаан, олс таталт, буухиа тэмцээн, цасан хотхон хийх төрлүүдэд оролцоог ханган оролцож гар барилдааны эрэгтэй, эмэгтэй төрөлд III байр, Буухиа тэмцээний төрөлд IV байранд шалгарч, амжилттай оролцсон.	60%



2. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, МУЗГ-ын 2024-2028 оны мөрийн хөтөлбөр “Эрүүл Монгол хүний төлөө” уриан дор зохион байгуулж буй Сонгинохайрхан дүүргийн ажилтан, албан хаагчдын дундах “Идэвхтэй хөдөлгөөн иргэн бүр” дасгалын аянд Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв оролцоог ханган

- Аэробикийн төрөлд Дэд байр
- Монгол бүжгийн төрөлд Гутгаар байр
- Ажлын байрны дасгал төрөлд Дэд байр
- Багийн нийт дүнгээр Дэд байранд тус тус шалгарч амжилттай оролцсон.



		Сонгино хайрхан дүүргийн эрүүл мэндийн төв Ажлын байрны дасгал-1 2026.04.01  You, Daarimaa Narmandakh and others 43 comments 204 shares	Сонгино Хайрхан Дүүргийн Эрүүл Мэндийн Төв Монгол бүжиг-1 бичлэг-1 2026.03.30  You, Purevsuren Zandan and others 54 comments 165 shares	
1.2 Ногоон хөгжлийн бодлого				
1.2.1	Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ.	Сонгинохайрхан дүүргийн Засаг Даргын Тамгын газраас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, хотын ногоон байгууламжиг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амвдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хаврын мод тарилтын нэгдсэн арга хэмжээнд 2026 оны 05 дугаар сарын 16-нд Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо, “Бумбатын рашаан”-д зохион байгуулсан тус арга хэмжээнд Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн 27 эмч, ажилтнууд оролцон 400 ширхэг мод, сөөг тарисан. 	100%	
Дүгнэлт		Нийслэл дүүргийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийн биелэлтийн хүрээнд Манай Эрүүл мэндийн төвд 2 бодлогын хүрээнд 9 ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Нийт хэрэгжилтийн дундаж хувь 78,8%		

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ДАРГА: Н.САРАНЗУЛ